



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А32

Сангивцдалай

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5 дахь заалт, сумын Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагаан-Овоо багийн "Өвөр хад" нутаг дэвсгэрт бог малын гоц халдварт мялзан өвчний голомт үүссэн тул постод гарч буй албан хаагчдад түлээ, нүүрс, хүнсээр хангасугай.

2. Уг арга хэмжээнд зарцуулах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр), нягтлан бодогч (Ж.Хишигсүрэн) зөвшөөрсүгэй.

3. Хорио цээрийн бүсэд хүн малын хөдөлгөөнд хяналт тавьж, хэв журам сахиулж ажиллахыг Эрэн хайх аврах салбарын дарга, Онцгой байдлын ахлах дэслэгч (Б.Энхтөр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ О.БАЗАРРАГЧАА



2823020063